



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/134


Улаанбаатар хот

Э.Дэлгэрмаад чөлөө олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн Иргэдийн өргөдөл, эрэлт хүсэлт үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Эрдэнэболдын Дэлгэрмаагийн төрсөн эцэг элэгний хорт хавдар тусаж, асаргаа шаардлагатай болсон тул гаргасан хүсэлтийг нь харгалзан Дотоод журмын 6 дугаар бүлгийн 6.19.6-д заасны дагуу 2019 оны 05 дугаар сарын 25-наас 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийг дуустал хугацаанд цалинтай чөлөө олгосугай.

2. Э.Дэлгэрмаагийн ажлыг орлон ажиллах хуваарийн дагуу холбогдох мэргэжилтэнд хүлээлцүүлж, эзгүй байх хугацаанд нь ажил үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Мөнгөндуулгад даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

